



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/71/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас:70584203 Цахим хаяг:Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг:Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 70584207 Цахим хаяг:Odkhuu@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.17 № 76

танай _____-ны № _____-т

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА О.БАЯРБАТ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520002



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга, цагдаагийн хурандаа О.Баярбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн НББ-ын тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 10-наас 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13з/16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Шинжлэх ухааны тодорхой салбарын шинжилгээ, судалгааны онол арга барилд түшиглэн хэргийн газрын үзлэгийг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэн хураан авах, хэргийн холбогдолтой ул мөр, эд мөрийн баримт материалуудад өндөр технологи бүхий лабораторийн техник хэрэгсэл ашиглан шүүх, прокурор, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын тогтоол, захирамжийн дагуу шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн зөв дүгнэлт, магадалгаа гаргаж өгөх”-д оршино.

Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Шүүхийн шинжилгээний албаны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 17 эрсдэлтэй асуудалд 17 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн



санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 184,350.9 мянган төгрөгөөс тооцон 3,687.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 3,888.5 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,139.0 мянган төгрөгөөр буюу 22.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс байхгүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	617.0	617.0	0
Үндсэн хөрөнгө	148,834.9	150,289.9	1,455.0
Элэгдэл	-64,757.2	-85,351.2	-20,594.0
Нийт хөрөнгө	84,694.7	65,555.2	-19,139.0
Өр төлбөр	579.5	191.0	-388.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	84,115.2	65,364.7	-18,750.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	84,694.7	65,555.7	-19,139.0

Авлага дансны үлдэгдэл байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өөрчлөлт гараагүй. Тайлант онд 9,547.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 9,547.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Бараа материалын данс нь өмнөх онд байсан 617,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,455.0 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны А-1/3912 дугаар албан бичгээр 665.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталж, үйл ажиллагааны давсан орлогоор худалдаж авсан 2,120.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 388.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны 579,518 төгрөгийн татварын өглөгийг барагдуулж, тайлант онд 191,0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэснээс шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр байхгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 65,364.7 мянган төгрөг болж 18,750.5 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны үр дүн буурснаас шалтгаалжээ. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн өндөр байгаатай холбоотой байна.



2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Шүүхийн шинжилгээний алба тайлант онд 9,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 14,818.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 164,7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	9,000.0	14,818.5	5,818.5	164,7
Нийт дүн	9,000.0	14,818.5	5,818.5	164,7

Үйл ажиллагааны орлого 5,818.5 мянган төгрөгөөр давсан нь аймгийн хэмжээнд гарсан гэмт хэрэг, зөрчил нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Шүүх шинжилгээ /70707/ хөтөлбөрт зориулан 170,035.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 170,035.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 161,035.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 9,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 169,856.4 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь тайлант хугацаанд төсвийн хуваарийн дагуу зардлыг зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 4,847.5 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтын зардалд 2,210.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэхэд 2,713.3 мянган төгрөг, нийт 4,833.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 14.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 17 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 16 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 11,414.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 9,165.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 2,249.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 9,165.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 9,165.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд хийсэн 9,165.6 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн



Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь заалт, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2. Цалингийн тооцооллыг дахин хийн шалгахад аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн Б/62 дугаар захирамжаар үр дүнгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2-д “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно:” 1.2.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид” гэсэн заалттай нийцэхгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

Аудитаар илэрсэн 2,249.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтад үндэслэн бүртгэлийг хөтлөх.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад



илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн талаар

1.1. Илрүүлэлт: Цалингийн тооцооллыг дахин хийн шалгахад цалингийн зардлаас НДШ-ийн зардалд 2,249.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсныг бүртгэлд зөрүүтэй тусгасан байна.

1.2. Эрсдэл: Тайлан баланс буруу илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийг мөрдөж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	617 000,00	617 000,00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00,00	00,00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00,00	00,00
35	БАРАА МАТЕРИАЛ	617 000,00	617 000,00
351	Түүхий эд материал	00,00	00,00
354	Хангамжийн материал	617 000,00	617 000,00
35470	Бусад хангамжийн материал	617 000,00	617 000,00
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	00,00	00,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	84 077 743,67	64 938 720,71
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00,00	00,00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	84 077 743,67	64 938 720,71
391	Газар	00,00	00,00
392	Биет хөрөнгө	59 077 743,67	39 938 720,71
39201	Барилга, байгууламж, орон сууц	00,00	00,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00,00	00,00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	64 978 310,00	64 978 310,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20 163 769,89	-30 143 561,95
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45 393 025,60	45 098 026,60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-37 143 791,01	-40 535 165,02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13 463 640,30	15 213 640,30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7 449 671,33	-14 672 529,22
393	Биет бус хөрөнгө	25 000 000,00	25 000 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	25 000 000,00	25 000 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	84 694 743,67	65 555 720,71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	579 518,00	00,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	579 518,00	191 001,00
413	Өглөг	579 518,00	191 001,00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	579 518,00	191 001,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	84 115 225,67	65 364 719,71
51	Засгийн газрын хувь оролцоо	84 115 225,67	65 364 719,71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	40 031 528,00	40 031 528,00
51101	Өмч: - төрийн	40 031 528,00	40 031 528,00
512	Хуримтлагдсан үр дүн	44 083 697,67	25 333 191,71
51210	Өмнөх үеийн үр дүн	44 083 697,67	44 083 697,67
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	-18 750 505,96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	84 694 743,67	65 555 720,71

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	208 097 300,00	175 868 620,00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00,00	00,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51 372 800,00	9 985 220,00
120	Нийтлэг татварын бус орлого	51 372 800,00	9 985 220,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	51 372 800,00	9 971 000,00



Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14 102 800,00	9 971 000,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	37 270 000,00	00,00
120009	Бусад орлого	00,00	14 220,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	156 724 500,00	165 883 400,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	156 724 500,00	161 035 900,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	156 724 500,00	161 035 900,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00,00	4 847 500,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00,00	4 847 500,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	185 276 880,62	191 619 125,96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	185 276 880,62	191 619 125,96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	178 637 705,62	193 454 412,93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130 737 752,00	135 071 725,97
210101	Үндсэн цалин	81 705 670,00	80 520 925,97
210102	Нэмэгдэл	35 040 082,00	40 558 800,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13 992 000,00	13 992 000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6 269 108,00	6 321 500,00
210201	Тэтгэврийн даатгал	3 661 972,00	2 821 500,00
210202	Тэтгэмжийн даатгал	200 000,00	200 000,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	250 000,00	250 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	50 000,00	50 000,00
210205	Эрүүл мэндийн даатгал	2 107 136,00	3 000 000,00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00,00	00,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3 012 548,00	3 250 000,00
210301	Гэрэл, цахилгаан	727 812,00	881 748,00
210302	Түлш, халаалт	1 561 371,00	1 160 974,00
210303	Цэвэр, бохир ус	723 365,00	1 207 278,00
210304	Байрны түрээс	00,00	00,00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00,00	00,00
2104	Хангамж, бараа материалын зардал	10 806 810,00	11 880 612,00
210401	Бичиг хэрэг	1 904 733,00	1 766 300,00
210402	Тээвэр, шатахуун	6 980 108,00	8 300 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	843 599,00	1 080 322,00
210404	Ном, хэвлэл	00,00	00,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00,00	141 050,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 078 370,00	592 940,00
2105	Нормативт зардал	4 601 260,00	4 105 762,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3 818 330,00	4 105 762,00
210502	Хоол, хүнс	782 930,00	00,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00,00	00,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 816 900,00	248 000,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	340 000,00	248 000,00
210604	Урсгал засвар	1 476 900,00	00,00
2107	Томилолт, зочны зардал	5 494 000,00	5 499 000,00
210701	Гадаад албан томилолт	00,00	00,00
210702	Дотоод албан томилолт	5 494 000,00	5 499 000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00,00	00,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 721 717,00	5 818 790,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 531 800,00	5 072 280,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00,00	240 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	133 100,00	208 320,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56 817,00	70 400,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00,00	60 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00,00	00,00
210807	Газрын төлбөр	00,00	167 790,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14 177 610,62	21 259 022,96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14 177 610,62	21 259 022,96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6 639 175,00	1 164 713,03
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6 639 175,00	1 164 713,03



Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6 639 175,00	1 164 713,03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>22 820 419,38</u>	<u>-18 750 505,96</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00,00	00,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>22 820 419,38</u>	<u>-18 750 505,96</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	170 827 300,00	175 868 620,00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00,00	00,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14 102 800,00	9 985 220,00
120	Нийтлэг татварын бус орлого	14 102 800,00	9 985 220,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14 102 800,00	9 971 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14 102 800,00	9 971 000,00
120009	Бусад орлого	00,00	14 220,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	156 724 500,00	165 883 400,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	156 724 500,00	161 035 900,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	156 724 500,00	161 035 900,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00,00	4 847 500,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00,00	4 847 500,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	170 431 300,00	173 748 620,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	170 431 300,00	173 748 620,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	163 792 125,00	172 583 906,97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130 779 527,00	135 460 242,97
210101	Үндсэн цалин	79 037 527,00	80 909 442,97
210102	Нэмэгдэл	37 750 000,00	40 558 800,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13 992 000,00	13 992 000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6 227 333,00	6 321 500,00
210201	Тэтгэврийн даатгал	2 727 333,00	2 821 500,00
210202	Тэтгэмжийн даатгал	200 000,00	200 000,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	250 000,00	250 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	50 000,00	50 000,00
210205	Эрүүл мэндийн даатгал	3 000 000,00	3 000 000,00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00,00	00,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3 012 548,00	3 250 000,00
210301	Гэрэл, цахилгаан	727 812,00	881 748,00
210302	Түлш, халаалт	1 561 371,00	1 160 974,00
210303	Цэвэр, бохир ус	723 365,00	1 207 278,00
210304	Байрны түрээс	00,00	00,00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	00,00	00,00
2104	Хангамж, бараа материалын зардал	11 007 860,00	11 579 992,00
210401	Бичиг хэрэг	1 742 950,00	1 334 400,00
210402	Тээвэр, шатахуун	6 980 108,00	8 300 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	981 082,00	1 020 322,00
210404	Ном, хэвлэл	00,00	00,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00,00	141 050,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 303 720,00	784 220,00
2105	Нормативт зардал	4 132 040,00	4 520 162,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3 342 360,00	4 520 162,00



Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	789 680,00	00,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00,00	00,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 504 000,00	313 500,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00,00	313 500,00
210604	Урсгал засвар	1 504 000,00	00,00
2107	Томилолт, зочны зардал	5 494 000,00	5 499 000,00
210701	Гадаад албан томилолт	00,00	00,00
210702	Дотоод албан томилолт	5 494 000,00	5 499 000,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00,00	00,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 634 817,00	5 639 510,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 419 900,00	4 893 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00,00	240 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	133 100,00	208 320,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56 817,00	70 400,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25 000,00	60 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00,00	00,00
210807	Газрын төлбөр	00,00	167 790,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6 639 175,00	1 164 713,03
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00,00	00,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6 639 175,00	1 164 713,03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6 639 175,00	1 164 713,03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	396 000,00	2 120 000,00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	396 000,00	2 120 000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	396 000,00	2 120 000,00
2200	Дотоод эх үүсвэрээр	396 000,00	2 120 000,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	396 000,00	2 120 000,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-396 000,00	-2 120 000,00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
14	Бусад эх үүсвэр	00,00	00,00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15 031 528,00	00,00	20 337 314,95	00,00	35 368 842,95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15 031 528,00	00,00	20 337 314,95	00,00	35 368 842,95
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00	00,00
C07	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	2 164 904,00	00,00	2 164 904,00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	40 031 528,00	00,00	44 083 697,67	00,00	84 115 225,67



Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	40 031 528,00	00,00	44 083 697,67	00,00	84 115 225,67
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00	00,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	40 031 528,00	00,00	44 083 697,67	00,00	84 115 225,67
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00	00,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00	00,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	-18 750 505,96	00,00	-18 750 505,96
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	40 031 528,00	00,00	25 333 191,71	00,00	65 364 719,71

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	164 724 500,00	164 188 125,00	170 035 900,00	169 856 406,97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	164 724 500,00	164 188 125,00	170 035 900,00	169 856 406,97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	164 724 500,00	164 188 125,00	170 035 900,00	169 856 406,97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	131 084 900,00	130 779 527,00	135 634 400,00	135 460 242,97
210101	Үндсэн цалин	79 342 900,00	79 037 527,00	81 083 600,00	80 909 442,97
210102	Нэмэгдэл	37 750 000,00	37 750 000,00	40 558 800,00	40 558 800,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13 992 000,00	13 992 000,00	13 992 000,00	13 992 000,00
210104	Урамшуулал	00,00	00,00	00,00	00,00
210105	Гэрээт ажлын хөлс	00,00	00,00	00,00	00,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6 321 500,00	6 227 333,00	6 321 500,00	6 321 500,00
210201	Тэтгэврийн даатгал	2 821 500,00	2 727 333,00	2 821 500,00	2 821 500,00
210202	Тэтгэмжийн даатгал	200 000,00	200 000,00	200 000,00	200 000,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	250 000,00	250 000,00	250 000,00	250 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	50 000,00	50 000,00	50 000,00	50 000,00
210205	Эрүүл мэндийн даатгал	3 000 000,00	3 000 000,00	3 000 000,00	3 000 000,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3 030 000,00	3 012 548,00	3 250 000,00	3 250 000,00
210301	Гэрэл, цахилгаан	738 600,00	727 812,00	900 000,00	881 748,00
210302	Түлш, халаалт	1 561 400,00	1 561 371,00	1 400 000,00	1 160 974,00
210303	Цэвэр, бохир ус	730 000,00	723 365,00	950 000,00	1 207 278,00
210304	Байрны түрээс	00,00	00,00	00,00	00,00
2104	Хангамж, бараа материалын зардал	11 042 000,00	11 007 860,00	11 580 000,00	11 579 992,00
210401	Бичиг хэрэг	1 757 100,00	1 742 950,00	1 200 000,00	1 334 400,00
210402	Тээвэр, шатахуун	7 000 000,00	6 980 108,00	8 300 000,00	8 300 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	981 100,00	981 082,00	700 000,00	1 020 322,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00,00	00,00	600 000,00	141 050,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 303 800,00	1 303 720,00	780 000,00	784 220,00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00,00	00,00	00,00	00,00
2105	Нормативт зардал	4 138 000,00	4 132 040,00	4 520 200,00	4 520 162,00



Дорнод аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3 348 000,00	3 342 360,00	4 520 200,00	4 520 162,00
210502	Хоол, хүнс	790 000,00	789 680,00	00,00	00,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 900 000,00	1 900 000,00	313 500,00	313 500,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	446 000,00	396 000,00	313 500,00	313 500,00
210604	Урсгал засвар	1 454 000,00	1 504 000,00	00,00	00,00
2107	Томилолт, зочны зардал	5 500 000,00	5 494 000,00	5 500 000,00	5 499 000,00
210701	Гадаад албан томилолт	00,00	00,00	00,00	00,00
210702	Дотоод албан томилолт	5 500 000,00	5 494 000,00	5 500 000,00	5 499 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 708 100,00	1 634 817,00	2 916 300,00	2 912 010,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 420 000,00	1 419 900,00	2 165 500,00	2 165 500,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00,00	00,00	240 000,00	240 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	150 000,00	133 100,00	208 400,00	208 320,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	108 100,00	56 817,00	70 400,00	70 400,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30 000,00	25 000,00	60 000,00	60 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00,00	00,00	00,00	00,00
210807	Газрын төлбөр	00,00	00,00	172 000,00	167 790,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	164 724 500,00	170 827 300,00	170 035 900,00	171 006 900,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	156 724 500,00	156 724 500,00	161 035 900,00	161 035 900,00
131001	Улсын төсвөөс санхүүжих	156 724 500,00	156 724 500,00	161 035 900,00	161 035 900,00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8 000 000,00	14 102 800,00	9 000 000,00	9 971 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8 000 000,00	14 102 800,00	9 000 000,00	9 971 000,00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	00,00	00,00	00,00	00,00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	00,00	00,00	00,00	00,00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12,00	11,00	12,00	11,00
620001	Удирдах ажилтан	01,00	01,00	01,00	01,00
620002	Гүйцэтгэх ажилтан	11,00	10,00	11,00	10,00
620003	Үйлчлэх ажилтан	00,00	00,00	00,00	00,00
620004	Гэрээт ажилтан	00,00	00,00	00,00	00,00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12,00	11,00	12,00	11,00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	00,00	00,00	00,00	00,00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	12,00	11,00	12,00	11,00